



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 368

Улаанбаатар хот

Г “Бүрэн төгрөг” ХХК-д Г  
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бүрэн төгрөг” ХХК-д банк бус санхүүгийн зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөлгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг Бүрэн төгрөг ББСБ ХХК/С.Долгормаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар/Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН